



**МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 1/420

Ховд

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 221 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн аюулгүйн нөөцөд хүчит тэжээл бэлтгэх зорилгоор 5,000,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 5,000,000 төгрөг (таван сая)-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дугаар хуралдааны 7/02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.3 дахь заалт, аймгийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг Даргын 2022 оны  
 06 дугаар сарын 30-ны өдрийн  
 А/420 дугаар захирамжийн  
 хавсралт

**АЮУЛГҮЙН НӨӨЦӨД ХҮЧИТ ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ  
 ЗАРДЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА**

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт дүн
1	Хүчит тэжээл	1 уут /30 кг/	300 уут	16 666,6	5 000 000
Нийт дүн					5 000 000

-oOo-